



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ



ОЮУНЫ  
ИННОВАЦИ  
ТББ

МОНГОЛ УЛС

ШҮҮХИЙН  
ИНДЕКС

2025

МОНГОЛ УЛС

ШҮҮХИЙН  
ИНДЕКС 2025

# Шүүхийн индексийн өгөгдлийн эх сурвалж

### 1. Олон нийтийн төсөөллийн санал асуулга (иргэд)

Олон нийтээс санал асуулга авах ажлыг зөвлөх үйлчилгээний “Эм Эм Си Жи” ХХК-аар гүйцэтгүүлсэн.

Олон нийтийн судалгаанд Улаанбаатар хот болон 21 аймаг, 330 сумын төлөөлөл болсон 18-аас дээш насны **2009** иргэнийг хамруулан **2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хугацаанд CAWI (интернэт/цахим хуудсанд суурилсан онлайн) болон утсаар-CATI** аргуудыг хослуулж хийж гүйцэтгэсэн. 111 шалгуур үзүүлэлтээс **37-г** нь олон нийтийн төсөөллийн санал асуулгаар авсан.

#### Түүврийн хэмжээ, бүсээр:

	Ангилал	Судалгаанд оролцогчийн тоо
Бүсчлэл	Баруун бүс	256
	Хойд бүс	186
	Хангайн бүс	183
	Төвийн бүс	187
	Говийн бүс	133
	Зүүн бүс	147
	Улаанбаатар хот	917
	Нийт	2,009

**Түүвэрт эзлэх хувь:** шүүхээр үйлчлүүлсэн иргэдийн тоог 15 хувиас багагүй, төрийн албан хаагчдын тоог 30 хувиас ихгүй байхаар тооцсон. 2,009 хүнээс 15.4 хувь нь буюу 309 хүн шүүхээр үйлчлүүлж байсан иргэн.

## 2. Мэргэжилтнүүдээс санал асуулга авах

- Санал асуулгад хамрагдах мэргэжилтнийг тодорхойлохдоо шүүх эрх мэдлийн үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар хамааралтай болох үүднээс **шүүгч, прокурор, өмгөөлөгч, бусад хуульчаас** асуулга авсан.
- “Оюуны-Инноваци” ТББ-аас 2026 оны 01, 02 дугаар сард мэргэжилтнүүдийн санал асуулгыг цахим хэлбэрээр явуулсан.
- 2025 оны судалгаанд **150 шүүгч, 100 өмгөөлөгч, 50 хуульч** оролцсон бол **423 прокурор** хамрагдсанаас мэргэжилтнүүдийн оролцооны тэнцвэртэй байдал, түүврийн төлөөлөх чадвар зэргийг тооцож, нас, хүйсийн жинг алдагдуулахгүйгээр 423 прокурорын асуумжаас санамсаргүй түүврээр **150-ыг** сонгон индекст ашигласан. нийт **500** мэргэжилтэн оролцсон нь нийт тоогоороо өмнөх судалгаанаас давсан.
- 2021 судалгаанд нийт **387**, 2023 онд **418** мэргэжилтэн оролцсонтой харьцуулахад судалгаанд хамрагдсан шүүгч, прокурор, өмгөөлөгчийн оролцоо нэмэгдсэн.
- Шүүхийн индексийн хүрээнд 111 шалгуур үзүүлэлтээс **55-ыг** нь мэргэжилтнүүдийн санал асуулгаар авсан.

### 3.Захиргааны мэдээлэл

(Статистик мэдээлэл)

- Монгол Улсын шүүхийн тайлан, Шүүхийн сахилгын хорооны үйл ажиллагааны тайлан, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас иргэн, захиргаа, эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн статистик мэдээлэл, бусад холбогдох судалгааны эх сурвалжаас “Оюуны-Инноваци” ТББ-ын судлаачид цуглуулж боловсруулсан.
- Шүүхийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлттэй холбоотойгоор “**6.3.Шүүгчийн ажлын ачаалал**” дэд дэмжигдэхүүн 3 шалгуур үзүүлэлттэй байсныг **6** болгож дэлгэрүүлсэн.
- Шүүхийн индексийн 111 шалгуур үзүүлэлтээс **19 шалгуур** үзүүлэлтийг захиргааны мэдээллээс авсан болно.

МОНГОЛ УЛС

ШҮҮХИЙН  
ИНДЕКС 2025

# Шүүхийн индекс тооцох арга зүй

## Шүүхийн индекс тооцох үндсэн алхам

### 1. Өгөгдөл цуглуулах

Индекс тооцоход шаардлагатай өгөгдлийг захиргааны мэдээлэл, олон нийтийн төсөөллийн санал асуулга, мэргэжилтнүүдийн санал асуулгаар цуглуулсан.

Санал асуулгын асуулт бүрийн хариултыг урьдчилж тоон утгаар кодлосон байна.

Асуултын агуулгаас хамаарч зарим асуултын хариултын байрлалыг эргүүлсэн. Бүх асуулгын хариулт бага утгаас (шүүхийн үйл ажиллагаа сул) их утга (шүүхийн үйл ажиллагаанд сайн) хүртэл нэгдсэн дараалалд оруулан нормализаци хийх шатад бэлтгэнэ.

### 2. Өгөгдлийг цэвэрлэх

Дутуу бөглөсөн, асуултад нэгээс илүү хариу өгсөн, “мэдэхгүй” гэж хариулт өгсөн асуулгыг хүчингүйд тооцон индекс боловсруулалтад хамруулаагүй.

Өгөгдлийн санг үр ашигтайгаар зохион байгуулах, хэмжигдэхүүн хоорондын утгыг нэгдсэн байдлаар харьцуулах боломжийг бий болгох зорилгоор хариулт бүрийг 0-эс 1 хүртэлх утгын хооронд нормализаци (min-max normalization) хийнэ. Томъёо:

$$z_i = \frac{x_i - \min(x)}{\max(x) - \min(x)}$$

$z_i$  – Нормалчилсан  $x_i$  утга

$x_i$  – Асуумжийн хариулт

$\max(x)$  –  $x$  дахь хамгийн их утга

$\min(x)$  –  $x$  дахь хамгийн бага утга

## Оноо өгөх арга зүй

Шалгуур үзүүлэлтийн индекс нь 0-100 онооны хооронд байх бөгөөд, 0 оноо нь шүүх засаглалын төлөв байдал маш сул гэж үзэх бол 100 оноо нь шүүх засаглалын төлөв байдал маш сайн гэж илтгэнэ. Шалгуур үзүүлэлтийн индексийн оноог тооцох дараалал:

1. Хариултуудыг тоон утгад шилжүүлнэ. Хүн бүр Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргах, хэрэг, маргаанаа шийдвэрлүүлэх эрхээр хангагдсан байдаг гэдэгтэй “Огт санал нийлэхгүй” гэж хариулсан иргэдийн хариултыг хамгийн бага тоон утга буюу 1 гэж кодлоно. “Санал нийлэхгүй” хариултыг 2, “Зарим талаар санал нийлнэ” хариултыг 3, “Санал нийлнэ” хариултыг 4, “Бүрэн санал нийлнэ” хариултыг 5 гэж кодлоно. “Мэдэхгүй” хариултыг индекс тооцоход оруулахгүй.

2. Кодлосон хариултуудыг дараах томъёогоор нормализаци хийж, 0-1 тоон утгад хөрвүүлнэ.

$$z_i = \frac{x_i - \min(x)}{\max(x) - \min(x)}$$

$z_i$  – Нормализаци хийсэн  $x_i$  утга

$x_i$  – Асуултын хариулт

$\max(x)$  –  $x$  дахь хамгийн их утга

$\min(x)$  –  $x$  дахь хамгийн бага утга

3. Хариултуудын нормализаци хийсэн тоон утгыг ашиглан судалгааны асуулт буюу тухайн шалгуур үзүүлэлтийн дундаж оноог тооцно.

## Оноо өгөх арга зүй

Хариултын сонголт	Хариултын тоон утга	Нормализаци хийсэн утга	Судалгаанд оролцогчдын тоо	Шалгуур үзүүлэлтийн индексийн оноо
	$(x_i)$	$z_i = \frac{x_i - \min(x)}{\max(x) - \min(x)}$	$(n)$	$\mu = \frac{\sum_{i=1}^n z_i}{n}$
1. Бүрэн санал нийлнэ	5	1	384	60.62
2. Санал нийлнэ	4	0.75	413	
3. Зарим талаар санал нийлнэ	3	0.50	879	
4. Санал нийлэхгүй	2	0.25	329	
5. Огт санал нийлэхгүй	1	0	0	
6. Мэдэхгүй	-	-	11	
Нийт			$N = 2016 - 11 = 2005$	

### Тайлбар:

ОНСА 4.1: Хүн бүр Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргах, хэрэг, маргаанаа шийдвэрлүүлэх эрхээр хангагдсан байдаг.

Судалгаанд нийт 2016 хүн хамрагдсан бөгөөд олон нийтийн төсөөллийн санал асуулгын 4.1 дүгээр асуултад 384 хүн “Бүрэн санал нийлнэ”, 413 хүн “Санал нийлнэ”, 879 хүн “Зарим талаар санал нийлнэ”, 329 хүн “Санал нийлэхгүй”, 11 хүн “Мэдэхгүй” гэж хариулсан байна.

Шүүхийн үйл ажиллагааны төлөв байдлыг бодитойгоор үнэлэх зорилгоор асуултад “Мэдэхгүй” гэж хариулсан оролцогчдын хариултыг индекс тооцоход оруулахгүй.

Ингэснээр ОНСА 4.1 асуултын “Мэдэхгүй” гэж хариулсан 11 хариултыг хасан 2009 хүний хариултыг индекс тооцоход ашиглана.

## Шүүхийн индекс тооцох үндсэн алхам

**3.Шалгуур үзүүлэлтийн дундаж утгыг тооцох**

Өгөгдлийг нормализаци хийсний дараа шалгуур үзүүлэлт бүрийн дундаж утгыг тодорхойлно.

**4.Дэд хэмжигдэхүүний дундаж утгыг тооцох**

Дэд хэмжигдэхүүний утгыг тодорхойлохдоо шалгуур үзүүлэлт бүрийн холбогдох жинг харгалзан дунджийг тодорхойлно.

**5.Үндсэн хэмжигдэхүүний дундаж утгыг тооцох**

Үндсэн хэмжигдэхүүн бүрийн утгыг тодорхойлохдоо дэд хэмжигдэхүүн бүрийн холбогдох жинг харгалзан дундаж утгыг тодорхойлно.

**6.Индексийн ерөнхий оноо тооцох**

Үндсэн хэмжигдэхүүн бүрийг холбогдох жинг харгалзан дундаж утгыг тодорхойлсноор индекс утгыг гарган авна.

## Жинлэх арга зүй

№	Үндсэн хэмжигдэхүүн	Дэд хэмжигдэхүүний тоо	Олон нийтийн санал асуулга	Мэргэжилтнүүдийн санал асуулга	Захиргааны мэдээлэл	Шалгуур үзүүлэлтийн тоо
1.	Шүүхийн эрх хэмжээ, бие даасан байдал	7	9	18	0	27
2.	Шүүхийн нээлттэй, ил тод байдал	9	7	8	1	16
3.	Шүүхэд итгэх олон нийтийн итгэл	6	10	9	0	19
4.	Шүүхийн дэд бүтэц, нөөц	7	5	10	0	15
5.	Шүүгчийн ёс зүй ба хариуцлага	6	3	8	1	12
6.	Шүүхийн үр ашигтай үйл ажиллагаа	7	3	2	17	22
<b>Нийт</b>		<b>42</b>	<b>37</b>	<b>55</b>	<b>19</b>	<b>111</b>

## Жинлэх арга зүй

№	Үндсэн хэмжигдэхүүн	Дэд хэмжигдэхүүний тоо	Шалгуур үзүүлэлтийн тоо	Эзлэх жин
1.	Шүүхийн эрх хэмжээ, бие даасан байдал	7	27	16.67%
2.	Шүүхийн нээлттэй, ил тод байдал	9	16	16.67%
3.	Шүүхэд итгэх олон нийтийн итгэл	6	19	16.67%
4.	Шүүхийн дэд бүтэц, нөөц	7	15	16.67%
5.	Шүүгчийн ёс зүй ба хариуцлага	6	12	16.67%
6.	Шүүхийн үр ашигтай үйл ажиллагаа	7	19	16.67%
<b>Нийт</b>		<b>42</b>	<b>111</b>	<b>100%</b>

1.Зөвхөн нэг шалгуур үзүүлэлттэй дэд хэмжигдэхүүний хувьд (олон нийтийн санал асуулга эсхүл мэргэжилтнүүдийн санал асуулга, эсхүл захиргааны мэдээлэл) тухайн шалгуур үзүүлэлийн дэд хэмжигдэхүүнд эзлэх жинг 100 хувь гэж үзсэн.

2.Хоёр буюу түүнээс дээш шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх дэд хэмжигдэхүүний хувьд (захиргааны мэдээлэл болон олон нийт, мэргэжилтнүүдийн санал асуулга, тэдгээрийн хослол) тус бүр нэг гэсэн хоёр үзүүлэлт бүхий дэд хэмжигдэхүүнүүдэд үзүүлэлт тус бүрд шалгуур үзүүлэлт бүрт ижил жинг тавьсан. Жишээ нь 2 шалгуур үзүүлэлтийн эзлэх жинг тус бүрд нь 50%, 3 шалгуур үзүүлэлтийн жинг тус бүрд нь 33.33%-аар тооцсон.

## Оноо өгөх арга зүй

- Индексийн жилийн утга 0-100 оноо, 0 ба 100 нь туйлын утга юм.
- 0 нь хамгийн сул утгыг илэрхийлнэ.
- 100 нь хамгийн сайн утгыг илэрхийлнэ.
- Бүх үзүүлэлтийн оноог 0-ээс 100-ын хооронд хувилна.
- Бүх шалгуур үзүүлэлтүүдийн жигнэсэн дундаж дүнгийн нийлбэр нь индексийн нийт оноог үүсгэнэ.

